

Аргачлалын тайлбар :

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Төсвийн орлого, зарлагын тооцоог Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн гаргаж байна. Төсвийн орлогын мэдээг аймгийн Татварын хэлтэс, төсвийн зарлага, санхүүжилтийн мэдээг СЭЗТС-ийн хэлтэсээс гаргадаг.

Төсвийн орлогын мэдээг хэрэглэгчдэд илүү тодорхой болгох зорилгоор аймгийн нийт төсвийн орлого, үүнээс улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, орон нутгийн төсөвт(аймгийн) төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт гэж салгаж харууллаа.

Төсвийн зарлагыг эдийн засгийн салбарын ангиллаар гаргаж, улсын төсвийн байгууллагууд, орон нутгийн төсвийн байгууллагууд гэж тус тусдаа гарсныг нэгтгэж орууллаа.

ҮНЭ

Аймгийн төвийн хүнсний зах дээр борлогдож байгаа хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдхүүн, ноос, ноолуур, арьс шир зэрэг зарим бүтээгдхүүний зах зээлийн дундаж үнийг харуулав.

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал, эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

2006 оноос эхлэн хэрэглээний сагсны нэр төрлийг шинэчилж 194 нэр төрөл болгож 2005 оны 12-р сарын үнээр суурилан ХҮИ-ийг тооцож байна.

АЖ ҮЙЛДВЭР

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаар нь ангилахдаа НҮБ-ийн эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдхүүний өсөлтийг гол нэр төрлийн бүтээгдхүүнийг 2000 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Гол нэр төрлийн бүтээгдхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

ХӨДӨЛМӨР

Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орно.

ЭРҮҮЛ МЭНД

Нялхсын нас баралт (1 хүртэл насны 1000 хүүхдэд ногдох)- ыг тухайн үед 1 хүртэлх насны нас барсан хүүхдийн тоог тухайн үед амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

ГЭМТ ХЭРЭГ

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулан тооцсоноор оны эхний 1 дүгээр сард аймгийн төсөвт 485.2 сая төгрөгийн орлого орж төлөвлөгөөг 100.0 хувиар биелүүлжээ.

Улсын төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулалгүйгээр аймаг өөрөө 204.7 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 240.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 117.3 хувиар биелүүлж, 35.4 сая төгрөгөөр давуулсан байна.

Үүнээс улсын төвлөрсөн төсөвт 155.7 сая төгрөгийг татвар, орлогын хэлбэрээр төвлөрүүлэхээс 191.1 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 122.7 хувиар биелүүлж 35.4 сая төгрөгөөр давууллаа. Аймгийн төсөвт 49.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна.

Ноднингийн мөн үетэй харьцуулахад аймгийн нийт төсвийн орлого 61.5 хувиар буюу 91.4 сая төгрөгөөр илүү, үүнээс аймагт төвлөрүүлсэн орлого 38.3 хувиар буюу 30.4 сая төгрөгөөр бага, харин улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлого 2.3 дахин буюу 121.8 сая төгрөгөөр илүү байна.

2010 оны 1 дүгээр сард улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогуудаас аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын орлогын төлөвлөгөө 50 хувиар тасарч

тоог жилийн дундаж 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.

ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ТАЙЛБАР :

1. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.(I, II, III, IV, V..... г.м)
I-XII жилийн эхний тухайн сарыг оруулсан өсөн нэмэгдэх дүнг харуулав. 1

2. Дараахь тэмдэглэлүүдийг ашиглав :

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй


Д - дахин

3. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрөх тохиолдол байж болно.

бусад нэр төрлүүд 105.4 - 136.5 хувиар биелэгдлээ.


1 дүгээр сард аймагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө хувиараа аж ахуй эрхлэгч иргэний орлого 72.7, орлого тодорхойлох боломжгүй иргэний орлогын татвар 53.8, авто өөрөө явагч хэрэгслэлийн татвар 90.3, бууны татвар 86.4, газрын төлбөр 73.9 хувиар тасарсан бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс мал бүхий иргэний орлогын татвар 66.7, хувиараа аж ахуй эрхлэгч иргэний орлого 50.0 хувиар, авто өөрөө явагч хэрэгслэлийн татвар 25.0 хувиар, газрын төлбөр 72.7 хувиар, татварын бус орлого 25.9 хувиар бага байна.

Төсвийн орлогын өсөлт, бууралт, онуудаар



— аймгийн төсвийн орлого — ОНТ-ийн орлого ба тусламж


Аймгийн төсвийн орлогын 89.9 хувийг тусламжийн орлогоор, 8.1 хувийг орлогын албан татвараар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлогын албан татвараар, 0.1 хувийг өмчийн албан татвараар, 0.9 хувийг бусад албан татвараар, 0.8 хувийг татварын бус орлогоор тус тус бүрдүүлсэн байна.



Ноднингийн мөн үетэй харьцуулахад тусламжийн орлогын эзлэх хувь 12.0 пунктээс өсч, орлогын албан татварын эзлэх хувь 9.3 пунктээр буурсан байна.

Аймгийн төсвийн зарлагад орлогын эзлэх хувь 42.7 хувь болсон нь сүүлийн 5 жилийн дунджаас 33.5 пунктээр илүү байгаа бөгөөд энэ нь төсвийн зарлагын хэмжээ ихээхэн буурснаас шалтгааллаа.

Төсвийн зарлагад орлогын эзлэх хувь, хувиар



2005 оны 1 дүгээр сарыг суурь болгон авч жил бүрийн 1 дүгээр сарын эцэстэй харьцуулахад аймаг өөрөө бүрдүүлсэн төсвийн орлого сүүлийн 2 жилд 2005 оны мөн үеэс 1.7 – 2.8 дахин өссөн байна.

Төсвийн орлого, зарлагын өсөлт, 2005 - I = 100 %

	2005 - I	2006 - I	2007 - I	2008 - I	2009 - I	2010 - I
Орлого	100.0	35.1	55.0	127.4	171.1	276.3
Зарлага	100.0	114.2	119.9	196.4	234.6	94.7

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Орон нутгийн төсвийн болон улсын төсвийн байгууллагуудын дүнгээр 562.4 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 2.5 дахин бага байгаа бөгөөд энэ нь 1 дүгээр сард зардлын гүйлгээнд хязгаарлалт хийсэнтэй холбоотойгоор багассан байна.

Нийт зарлагын 60.4 хувийг цалин хөлсөнд, 4.4 хувийг эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлд, 11.7 хувийг бусад зардалд, 9.9 хувийг урсгал шилжүүлэгт, 13.7 хувийг хөрөнгө оруулалтанд зориулан зарцууллаа.

Өнгөрсөн оны мөн үеэс цалингийн зардлын эзлэх хувь 12.3 пунктээр, НДШ-ийн зардлын эзлэх хувь 1.7, бусад зардлын эзлэх хувь 4.9 пунктээр бага байна.


Төсвийн зардлын 33.5 хувийг төрийн үйлчилгээ, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаанд, 32.6 хувийг боловсрол, 22.3 хувийг эрүүл мэндийн салбарт, 0.2 хувийг нийгмийн даатгал, халамжийн үйл ажиллагаанд, 1.3 хувийг ХАА-н салбарт, 6.6 хувийг ус цаг уур, байгаль

орчны үйл ажиллагаанд зориулан зарцууллаа.


Ноднингийн мөн үетэй харьцуулахад төрийн үйлчилгээний салбарт зориулсан зардын эзлэх хувь 13.4 пунктээр, эрүүл мэндийн салбарынх 3.5 пунктээр тус тус өсч, боловсролын салбарынх 24.8 пунктээр буурсан байна.

Төсөвт 178 байгууллагуудад 4.2 мянган хүн ажиллаж, ажиллагсдын тоо өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байна.

2010 оны 01 сар, хувиар




2009 оны 01 сар, хувиар



ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨГЛӨГ, АВЛАГА

Аймгийн төсөв 2010 оны 1 дүгээр сард 42.4 сая төгрөгийн өртэй, 84.2 сая төгрөгийн авлагатай, өнгөрсөн оны мөн үеэс өглөг 40.0 сая төгрөгөөр буюу 17 дахин, авлага 54.1 сая төгрөгөөр буюу 2.8 дахин өссөн байна.

1 дүгээр сард 28.4 сая төгрөгийн өр шинээр үүсч, сарын эцэст 4.2 сая төгрөгийн цалингийн, 139.4 мянган төгрөгийн НДШ –ийн, 4.2 сая төгрөгийн түлш, халаалтын, 16.8 сая төгрөгийн цэвэр, бохир усны, 2.3 сая төгрөгийн тээвэр шатахууны, 763.4 мянган төгрөгийн шуудан холбооны, 314.3 мянган төгрөгийн хоолны, 6.2 сая төгрөгийн байрны түрээсийн, 7.5 сая төгрөгийн бусад зардлын өртэй гарсан байна.



2010 оны 1 дүгээр сард байгаа өглөг, авлагын хэмжээг сүүлийн 3 жилийн дундажтай харьцуулахад өглөг 4.5 дахин, авлага 18.5 дахин буюу 40.2 сая төгрөгөөр өссөн байна

МӨНГӨ, ЗЭЭЛ

Монгол банкны мэдээгээр 652 сая төгрөг зузаатгалаар авч, 6.9 тэрбум төгрөг гүйлгээнд

гаргаснаас 7.3 тэрбум төгрөгийг буюу 105.8 хувийг эргүүлэн татсан байна.


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зузаатгалаар авсан мөнгө 312.0 сая төгрөгөөр буюу 91.8 хувиар өсч, гүйлгээнээс татсан мөнгө 438.7 сая төгрөгөөр буюу 5.7 хувиар, гүйлгээнд гаргасан мөнгө 78.8 сая төгрөгөөр буюу 1.1 хувиар тус тус буурсан байна.

Зээлийн өрийн үлдэгдэл 26.3 тэрбум төгрөг, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 1.4 тэрбум төгрөг болж ноднингийн мөн үеэс бүх зээлийн үлдэгдэл 2.0 тэрбум төгрөгөөр буюу 7.1 хувиар буурч, хугацаа хэтэрсэн зээл 1,0 тэрбум төгрөгөөр буюу 4 дахин өсчээ.


1,0 тэрбум төгрөгийн найдваргүй зээл байгаа нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.9 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 912.2 сая төгрөгөөр буюу 8.5 дахин өссөн байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 12.3 тэрбум төгрөг болж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 15.6 хувиар буюу 1.6 тэрбум төгрөгөөр өссөн, оны эцсээс 20.3 хувиар бурсан байна.

Нийт зээлийн 5.3 хувь нь хугацаа хэтэрсэн зээл байгаа бөгөөд Төрийн банкны нийт зээлийн 7.7, Шуудан банкны 7.7, ХААН банк 5.3, Хас банкны 2.3, Хадгаламж банкны 26.7 хувийг хугацаа хэтэрсэн зээл тус тус эзэлж байна.



Арилжааны банкуудын нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хувь



Хэрэглээний үнийн индекс

2010 оны 1-р сард судлагдаж буй 194 өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф өмнөх оны мөн үеэс 6.2, оны эхнээс 2.1, суурь буюу 2005 оны 12 сараас 72.7 хувь өсчээ.


Өмнөх сараас мах махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 6.4, жимс, талх гурил будааны дэд бүлгийн үнэ 1.4, хувцас бөс барааны дэд бүлгийн үнэ 1.1, орон сууц цахилгаан, түлшний дэд бүлгийн үнэ 0.2, гэр ахуйн тавилга барааны бүлгийн үнэ 2.4, тээврийн бүлгийн үнэ 0.4, амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ 2.6, зочид буудал нийтийн хоолны бүлгийн үнэ 2.8 хувь өсч бусад бүлгийн үнэ тогтвортой байлаа.

Гол нэрийн барааны өсөлтийн хувь

	өнгөрсөн оноос	ӨОМҮГ-с
цагаан будаа	7.7	27.3
хонины мах	11.1	0.0
хиам	5.3	0.0
сүү	6.3	13.3
үзэм	25.0	25.0
төмс	25.0	0.0
сонгино	0.0	50.0
элсэн чихэр	21.4	54.5



Сүүлийн 4 жилийн 1 саруудыг өмнөх сартай харьцуулсан индекс,



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулснаар барааны бүлгүүдээр үнийн өөрчлөлтийг тооцож үзвэл :

Хүнсний бараа, ундаа ус 2.8 %	Хүнсний бараа, ундаа усны бүлгийн үнэ 2.8 хувь өссөн нь сүү сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 14.3 %, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 4.1 саазарын дэд бүлгийн 25.0 хувь хүнсний бусад бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 43.2, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 12.3 хувь өссөнтэй холбоотой байна.
Согтууруулах ундаа, тамхи 11.0 %	Согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 11.0 % өссөн нь согтууруулах ундааны дэд бүлгийн үнэ 11.4, тамхины бүлгийн үнэ 10.3 % өссөнтэй холбоотой байна.
Хувцас гутал бөс бараа, гутал 18.6 %	Хувцас, гутал, бөс барааны бүлгийн үнэ дүнгээрээ 18.6 хувь өссөн нь хөвөн бөс барааны бүлгийн үнэ 24.4, бүх төрлийн хувцасны дэд бүлгийн үнэ 16.6 % үүнээс эрэгтэй бэлэн хувцасны дэд бүлгийн үнэ 16.9 %, эмэгтэй бэлэн хувцасны дэд бүлгийн үнэ 9.2 %, хүүхдийн бэлэн хувцасны дэд бүлгийн үнэ 24.6 жижиг эдлэл хэрэгслийн дэд бүлгийн үнэ 30.2, гутлын дэд бүлгийн үнэ 7.4 хувь өссөнтэй холбоотой байна.
Орон сууц, ус цахилгаан түлш 5.1 %	Орон сууц, түлш цахилгааны бүлгийн үнэ дүнгээрээ 5.1 хувь өссөн нь орон сууцны засвар үйлчилгээний дэд бүлгийн үнэ 6.2, усан хангамжийн дэд бүлгийн үнэ 3.3, цахилгаан болон хийн түлшний дэд бүлгийн үнэ 4.6 хувь өссөнтэй холбоотой байна.
Гэр ахуйн бараа, тавилга 10.3 %	Гэр ахуйн бараа, тавилганы бүлгийн үнэ дүнгээрээ 10.3 хувь өссөн нь гэрийн тавилганы бүлгийн үнэ 14.8 %, цахилгаан барааны бүлгийн үнэ 17.3 %, гэр ахуйн шилэн эдлэл, сав суулганы барааны бүлгийн үнэ 28.0 %, өмөөл, ихэмэл эдлэлийн үнэ 3.0 % өссөнтэй холбоотой байна.
Эм тариа эмнэлгийн үйлчилгээ -0.3 %	Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.3 % буурсан нь эм тарианы дэд бүлгийн үнэ 2.6 % буурсантай холбоотой байна.
Тээвэр -4.9 %	Тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 4.9 % буурсан нь хувийн тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний дэд бүлгийн үнэ 7.9 %, тээврийн үйлчилгээний дэд бүлгийн үнэ 4.2 хувь буурсантай холбоотой байна.
Амралт чөлөөт цаг соёлын үйлчилгээ 7.3 %	Амралт чөлөөт цаг соёлын үйлчилгээний бүлгийн үнэ 7.3 % өссөн нь дуу дүрс гэрэл зургийн мэдээллийн хэрэгслийн дэд бүлгийн үнэ 18.7 %, чөлөөт цаг соёлын үйлчилгээний дэд бүлгийн үнэ 1.5 % өссөнтэй холбоотой байна.
Боловсролын үйлчилгээ 20.7 %	Боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 20.7 % өссөн нь их дээд сургуулийн төлбөр 20.7 хувиар өссөнтэй холбоотой байна.
ЗБ нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 7.4 %	Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 7.4 % өссөн нь нийтийн хоолны үйлчилгээний дэд бүлгийн үнэ 9.1 хувь өссөнтэй холбоотой байна.
Бусад бараа үйлчилгээ 4.6 %	Бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.6 % өссөн нь хувь хүнд хандсан үйлчилгээ 8.2 % өссөнтэй холбоотой байна.


Ажилгүйдэл

Хөдөлмөр зохицуулах албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй эрж буй 2279 ажилгүйчүүд байгаагийн 49.5 хувь нь буюу 1127 эмэгтэйчүүд байна.

Насанд хүрсэн 10.0 мян хүнд 470 ажилгүйчүүд ноогдож байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 37.1 хувиар өссөн байна.

Оны эхний 1 сарын байдлаар ажилгүйчүүдийн тоо сүүлийн 4 жилийн дунджаас 22.4 хувиар өссөн байна.


Ажилгүйчүүдийн тоо сүүлийн 5 жилээр




Энэ 1-р сард 36 хүн ажилгүйчүүдэд нэмж бүртгэгдэн ажилгүй байсан хүмүүсээс 7 хүн ажлын байнгын болон түр байраар хангагджээ.

1-р сард ажилгүйчүүдэд бүртгүүлэгчдийн 5.6 хувь нь орон тооны цомхтголоос, 2.8 хувь нь сургууль төгссөн, 91.6 хувь нь бусад шалтгаанаар бүртгүүлсэн, ажилд орогчид 100 хувь нь бусад газарт ажилд орсон байна.

ХХҮХ-т шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон хүний тоо, жил бүрийн эхний 1 сараар



Ажилгүйчүүдийн 0.5 хувь нь анх удаа ажил эрж байгаа бөгөөд 53.5 хувь 16-34 насны залуучууд, 17.3 хувь нь дээд, 9.1 хувь нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 70.6 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой, 3.0 хувь нь бага болон боловсролгүй хүмүүс эзэлж байна.




Том малын зүй бус хоргодол

Оны эхний малын 2.1 хувь буюу 48.9 мянган толгой мал хоргодсон нь өнгөрсөн оноос 2.5 дахин буюу 29.0 мянган толгойгоор илүү байна.


Нийт хорогдлын 2.0 хувийг өвчний хоргодол эзэлж байна. 4830 хээлтэгч мал хоргодсон нь том малын зүй бус хоргодлын 9.9 хувийг эзэлж байна.

Нийт хорогдлын 40.0 хувийг хонь, 53.0 хувийг ямаа, 5.0 хувийг үхэр, 2.0 хувийг адууны хоргодол эзэлж байна.

Сүүлийн 5 жилийн том малын хоргодол .тол




Нийт хоргодолд эзлэх хувь



Өмнөговь, Хяргас, Улаангом, Өлгий, Баруунтуруун, Түргэн, Зүүнговь, Сагил, Тариалан сумдын оны эхний малын 2.2 – 4.9 хувь нь хоргодож аймгийн дунджаас 0.1 - 2.8 пунктээр их, бусад сумдын оны эхний малын 0.1 – 1.9 хувь нь хоргодсон нь аймгийн дунджаас 0.2 – 2.0 пунктээр бага байна.

Гамшгийн байдалтай сумдын хоргодол / сүүлийн 2 жилээр/



Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дундаж үнэ

2009 оны 9 дүгээр сараас эхлэн хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн болох 119 нэрийн бүтээгдэхүүний үнийг бүх сумдаас цуглуулан авч аймгийн дундаж үнэ тооцож байна. Бүтээгдэхүүний нэр, төрлийг нилгээд задалж ангилсан учир өнгөрсөн жилүүдтэй харьцуулах боломжгүй тул өмнөх сартай харьцуулж танилцуулна.

Малын үнэ 2010 оны 1-р сарын 31-ий байдлаар аймагт өсвөр насны мал болон тэмээ, буур 222.8 – 380.0 мянга, өсвөр болон нас гүйцсэн адуу, азарга 157.8 – 333.3 мянга, өсвөр насны болон нас гүйцсэн үхэр, бух 175.0 – 301.4 мянга, өсвөр насны төлөг, нас гүйцсэн эр ба эм хонь, хуц 21.5 – 50.0 мянга, өсвөр насны борлон, нас гүйцсэн эр ба эм ямаа, ухна 15.9 – 35.7 мянган төгрөгний дундаж үнэтэй байна.

Аймгийн дунджаас Баруунтуруун, Тэс, Цагаанхайрхан, Хяргас, Тариалан суманд өсвөр болон нас гүйцсэн тэмээ,

ингэ, буурны үнэ 1.3 – 57.7 мянган төгрөгөөр, Цагаанхайрхан, Тэс суманд өсвөр нас ба нас гүйцсэн адуу, гүү, азарганы үнэ 16.7 – 92.2 мянган төгрөгөөр, Цагаанхайрхан, Давст, Баруунтуруун, Наранбулаг, Тариалан, Тэс суманд бүх насны үхрийн үнэ 4.5 – 54.5 мянган төгрөгөөр тус тус илүү байна. Харин бог малын хувьд Зүүнговь, Зүүнхангай, Сагил, Цагаанхайрхан, Наранбулаг суманд 1.0 – 14.2 мянган төгрөгөөр илүү ханштай байна.

1 дүгээр сарын 31 - ний байдлаар бүх насны ямаа, эр ба эм хонь, үнээ, азарга, гүүний үнэ өмнөх сартай харьцуулахад 0.7 – 7.0 мянган төгрөгөөр өсч, бусад малын үнэ 5.1 – 41.7 мянган төгрөгөөр тус тус буурчээ.

ХАА - н зарим бүтээгдхүүн:


Гол нэрийн бүтээгдхүүн болох ноолуур 30.0 мянга, адууны шир 13.0 мянга, үхрийн шир 6.7 мянга, хонины арьс 1500, ямааны арьс 11000 төгрөгийн дундаж үнэтэй байна.

Мал, амьтны гаралтай зарим түүхий эдийн үнийг өмнөх сартай харьцуулахад үхрийн шир, ноолуурын үнэ 750 – 5000 төгрөгөөр өсч, ямаа ба хонины арьс, адууны ширний үнэ 500 - 4000 төгрөгөөр буурчээ. Харин үнээний сүү 100 төгрөг, хонины махны үнэ 200 төгрөгөөр тус тус өсчээ.

Газар тариалан болон бусад бүтээгдэхүүн:

Улаан буудай 458.3 мянга, задгай өвс 113.0 мянга, боодолтой өвс 4206, түлээний мод 22380, чацаргана 4000, сонгино 1500 төгрөгийн дундаж үнэтэй байна.

Өмнөх сартай харьцуулахад улаан буудай 41.7 мянган төгрөг, чацаргана 750 төгрөг, түлээний мод 663 төгрөгөөр тус тус буурч, боодолтой өвс 365 төгрөг, задгай өвсний үнэ 24.1 мянган төгрөгөөр өсчээ.




Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 387.0 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.4 хувиар буюу 9.3 сая төгрөгөөр буурсан нь хүнс, ундааны болон бусад боловсруулах

үйлдвэрийн бууралтаас шалтгаалсан байна.


Түүхий эдийн нөөц болон зах зээл дээрхи олдоц, хэрэглэгчийн зохистой хэрэглээ зэргээс шалтгаалж архи, өлөн гэдэс, цэвэр ус түгээлт, шевро, булигаарын үйлдвэрлэлтүүд буурсан нь түлхүү нөлөөллөө.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өсөлт бууралт /сая төг/, 2005 оны зэрэгцүүлэх үнээр



Нийт үйлдвэрлэлтийн 51.0 хувийг хүнс ундааны үйлдвэрлэл, 25.2 хувийг эрчим хүч түгээлт, 9.2 хувийг нүүрс олборлолт, 12.3 хувийг бусад боловсруулах үйлдвэрлэл, 1.1 хувийг усан хангамж, 1.1 хувийг хувцас үйлдвэрлэл эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтэц хувиар, 2010 оны 01 сар



Өнгөрсөн оны мөн үеэс /зэрэгцүүлэх үнээр тооцсоноор/ нүүрс олборлолт 33.3, хувцас үйлдвэрлэл 11.7, эрчим хүч түгээлт 1.0 хувиар өсч, хүнс ундааны үйлдвэрлэл 5.1, усан хангамж 20.6, бусад боловсруулах үйлдвэрлэл /өлөн,шевро,булигар,хөх шир/ 20.4 хувиар тус тус буурсан байна.

Оны үнээр 611.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 692.6 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж, өнгөрсөн оны мөн үеэс борлуулалтын орлого 8.0 хувиар өссөн байна. Нийт борлуулалтын 11.5 хувь буюу 80.0 сая төгрөгийн боловсруулсан өлөн гэдэс болон нүүрс гадаадад экспортолсон байна.


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад аж үйлдвэрийн салбарт эзлэх эрчим хүч түгээлт 2.0, нүүрс олборлолт 1.8 пунктээр өсч, хүнс ундааны үйлдвэрлэлтийн хувь 3.2, бусад боловсруулах үйлдвэрлэл 0.5, усан хангамж 0.5 пунктээр буурсан байна.

Салбарын бүтэц

	2008-I	2009-I	2010-I
Цахилгаан дулаан түгээлт	48.2	23.2	25.2
Нүүрс олборлолт	16.1	7.4	9.2
Бусад ашигт малтмал олборлолт	0	0	0
Хүнс ундаа үйлдвэрлэлт	32.4	54.2	51.0
Хувцас үйлдвэрлэлт	0.7	1.1	1.1
Мод модон бүт үйлдвэрлэлт	0	0	0
Бусад боловсруулах аж үйлдвэр	0.7	12.8	12.3
Усан хангамж	1.9	1.3	1.1
Дүн	100.0	100.0	100.0


2005 оны зэрэгцүүлэх үнээр тооцсоноор суурь буюу 2005 оноос боловсруулах үйлдвэрлэл 4.5 дахин, уул уурхай олборлолтын салбар 93.5 хувиар, эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэл 2.8 хувиар өссөн байна.

аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт
бууралт/2005 I =100%/




Аж үйлдвэрийн салбарын зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг 2005 оны мөн үетэй харьцуулбал өлөн 12.0, архи 3.9 ундаа 3.6, нарийн боов 75.7, нүүрс 93.5, дулаан 20.2 хувиар, түгээсэн цэвэр ус 2.6 хувиар өсчээ.


гол нэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт
(2005=100%/)



Гол нэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт хувиар
2005=100%/




гол нэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт хувиар 2005=100%



2005 оноос импортын цахилгаан 17.3, цахилгааны хэрэглээ 16.2 хувиар өссөн байна.

Цахилгааны хэрэглээ




Аж үйлдвэрийн чиглэлийн аж ахуйн нэгжүүд 23 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний гол нэр төрлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд өсөлт гарч 8 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурч, өнгөрсөн оны түвшинд 2 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгдсэн байна.

Гол нэрийн бүтээгдэхүүнээс сироп 6.0, ундаа 3.3, дээл 2.5 дахин, нүүрс 33.3, нарийн боов 29.0, гутал 20.6 хувиар өсч, талх 76.4, булигар 62.5 шевро 60.0, цэвэр ус түгээлт 20.6, өлөн 19.9, архи 15.6, хэрчсэн гурил 14.3, чацарганы тос 6.2, хувиар тус тус буурсан байна.

Зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

		2006	2007	2008	2009	2010
нүүрс	тн	3.6	3.5	4.6	4.5	6
архи	мян л	33.4	61.9	0	44.2	37.3
ундаа	мян л	3.6	4.8	1.2	3	10.1
нарийн боов	тн	11.2	45	30.3	24.1	31.1
өлөн	мян гог	0	0	0	37.6	30.1

Зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт/биет хэмжээгээр/



Эрүүл мэнд

Энэ оны эхний 1-р сард 185 эхээс 186 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төрсөн хүүхдийн тоо 24-өөр буюу 11.4 хувиар бага байна.


Гэрийн төрөлт 7 гарсан нь өнгөрсөн оноос 5 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Хүн амын нас баралт 54 гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 38.5 хувь буюу 15 тохиолдлоор нэмэгдэж 1000 хүнээс 1 нь нас барсан байна.


Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 59 ноогдож, өнгөрсөн оны мөн үеэс 5 гаралтаар буюу 83.3 хувиар нэмэгджээ.



■ нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөнд
■ 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөнд



■ төрөлт ■ нас баралт




5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Тэс, Зүүнговь, Наранбулаг, Давст, Баруунтуруун, Өлгий сумдад аймгийн дунджаас өндөр Улаангом суманд бага, бусад сумдад гараагүй байна.

0-1 насны хүүхдийн эндэгдэл 7 гарч нялхсын эндэгдлийн түвшин 38 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1 гаралтаар буюу 9 промилээр нэмэгджээ.


Нийт нас баралтын 23.2 хувийг эмнэлэгийн нас баралт, үүний 17.2 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна.

2 эх эндэж, 100.0 мянган амьд төрөлтөнд 1075 эхийн эндэгдэл ноогдож өнгөрсөн оны мөн үеэс эхийн эндэгдэл 2 дахин нэмэгдсэн байна. Осол гэмтлийн улмаас 4, хорт хавдрын улмаас 13 хүн нас баржээ.




Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 53 болж өнгөрсөн оны мөн үеэс 51.8 хувиар буюу 56 гаралтаар буурсан байна.



10000 хүн тутмаас 7 нь халдварт өвчнөөр өвчилж байгаа бөгөөд энэ үзүүлэлт Улаангом / 14.2 /, Өмнөговь / 11.8 /, Тэс / 9.2 / сумдад аймгийн дунджаас дээгүүр Ховд, Сагил, Цагаанхайрхан, Малчин, Зүүнговь, Тариалан, Наранбулаг сумдад аймгийн дунджаас доогуур, бусад сумдад гараагүй байна.



Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 18.9 хувь нь гепатит, 22.6 хувь нь БЗХӨ, 5.7 хувь нь сүрьеэгээр, 5.7 хувь нь мөөгөнцрөөр, 17.0 хувь нь гахайн хавдраар, 30.1 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилжээ.



Өнгөрсөн оны мөн үеэс гепатит 21, хамуу 8, бруцеллөз 1, трихоманиаз 2, тэмбүү 4, салхинцэцэг 37 гаралтаар буурч, хүйтэн 5, гахайн хавдар 9, мөөгөнцөр 3, хүйтэн 5, сүрьеэ 1 гаралтаар тус тус нэмэгджээ.




Амбулаториор 30.2 мянган хүнд үзлэг хийгдэж, стационариар 2.0 мянган хүн эмчлэгдсэн байна.

Хувийн хэвшлийн 10 эмнэлэг 0.9 мянган хүнд үзлэг эмчилгээ, оношлогоо хийж 7.1 сая төгрөгийн орлоготой ажиллажээ.

Гэмт хэрэг

Оны эхний 1 сард бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 37 болж өнгөрсөн оны мөн үеэс 37.0 хувиар, сүүлийн 4 жилийн дунджаас 17.5 хувиар тус тус өсч, гэмт хэрэгт холбогдогч 31 болж өнгөрсөн оны мөн үеэс 24.0 хувиар өссөн байна.

Бүрт гэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 1 сараар



Гэмт хэрэгт холбогдогчдоос 3.2 хувь буюу 1 нь хүүхэд байгаа бөгөөд өнгөрсөн оны түвшинд байна, харин эмэгтэй холбогдогч оны эхний 1 сард байхгүй байна.

Гэмт хэргийн улмаас иргэд байгууллагад 34.7 сая төгрөгийн хохирол учраад байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 11.9 хувиар буурсан байна. Гэмт хэргийн 21.6 хувь нь бүлэглэж үйлдсэн, 24.3 хувь нь согтуугаар үйлдэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бүлэглэсэн хэрэг 0.6 пунктээр буурч, харин согтуугаар үйлдсэн хэрэг 20.6 пунктээр буюу гаралтын тоо 9 дахин өссөн байна.

Гэмт хэргийн өнгөөр авч үзвэл өнгөрсөн оны мөн үеэс хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 2 дахин, үүний дотроос иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг хэрэг 83.3 хувиар тус тус өссөн байна.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 22.2 хувиар, үүний дотроос нийт хулгайн гэмт хэрэг 46.7

хувиар буурсны дотор малын хулгай 46.2 хувиар тус тус буурсан байна.

Тээврийн хэрэгслэлийн ХАБ, ашиглалтын журмын эсрэг хэрэг 2 дахин өссөн бөгөөд өнгөрсөн 1 сард гарч байгаагүй нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, захиргааны журмын эсрэг гэмт хэргүүд 3-4 тохиолдол гарсан байна.



Шүүхээр 14 гэмт хэрэгт 19 хүн ял шийтгүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс шийтгүүлсэн гэмт хэрэг 53.3 хувиар, шийтгүүлсэн хүний тоо 63.5 хувиар тус тус буурсан байна.

Шүүхээр таслуулсан гэмт хэрэг, ял шийтгүүлсэн хүний тоо жилийн эцсээр



ЦАГ УУРЫН БАЙДАЛ

2010 оны 1-р сард агаарын дундаж температур Улаангом, Баруунтуруун, Давст, Зүүнговь, Тэс -33.6-ээс -37.3 хэм хүйтэн, хөрсний дундаж температур Зүүнговь, Баруунтуруун, Давст, Тэс сумдад -34.7 ээс -37.7 хэм хүйтэн байлаа.

10 м/сек –ээс их салхитай өдөр Зүүнхангайд 15, Наранбулагт 6, Цагаанхайрханд 5 хоног байв.

Баруунтуруунд 6, Өмнөговьд 6, Завханд 8, Малчинд 6, Сагилд 7, Улаангомд 6, Зүүнхангайд 6 хоног тундастай байж нийлбэрээрээ Баруунтуруунд 5.6 мм, Малчинд 5.6 мм, Сагилд 8.1 мм, Түргэнд 9.6 мм цас орсон нь аймгийн хэмжээнд хамгийн их тундастай сумдууд болж байна.

Цасны зузаан Баруунтуруун 22 см, Малчин 24 см, Улаангом 28 см, Зүүнговь 22 см, Сагил 24 см, Түргэн 40см байгаа нь бусад сумдаас харьцангуй илүү байна.

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН

ДАРГА

Ж.ЭРДЭНЭСҮРЭН

ЦАГ УУРЫН БАЙДАЛ

2010 оны 1-р сард агаарын дундаж температур Улаангом, Баруунтуруун, Давст, Зүүнговь, Тэс -33.6-ээс -37.3 хэм хүйтэн, хөрсний дундаж температур Зүүнговь, Баруунтуруун, Давст, Тэс сумдад -34.7 ээс -37.7 хэм хүйтэн байлаа.

10 м/сек –ээс их салхитай өдөр Зүүнхангайд 15, Наранбулагт 6, Цагаанхайрханд 5 хоног байв.

Баруунтуруунд 6, Өмнөговьд 6, Завханд 8, Малчинд 6, Сагилд 7, Улаангомд 6, Зүүнхангайд 6 хоног тундастай байж нийлбэрээрээ Баруунтуруунд 5.6 мм, Малчинд 5.6 мм, Сагилд 8.1 мм, Түргэнд 9.6 мм цас орсон нь аймгийн хэмжээнд хамгийн их тундастай сумдууд болж байна.

Цасны зузаан Баруунтуруун 22 см, Малчин 24 см, Улаангом 28 см, Зүүнговь 22 см, Сагил 24 см, Түргэн 40см байгаа нь бусад сумдаас харьцангуй илүү байна.

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН

ДАРГА

Ж.ЭРДЭНЭСҮРЭН